ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн төсвөөс санхүүжсэн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/114/НА-СА-ТШ3

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Сувдмаа

Утас: 70373089 Цахим хаяг: Suvdmaakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.16 № 8/

таны ______ -ны № ______ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА С.ЭНХБОЛД ТАНАА

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн төсвөөс санхүүжсэн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн төсвөөс санхүүжсэн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР

0090?0054

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

*(төгрөгөөр)*

| Дансны код | Балансын үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|---|
| **Санхүүгийн байдлын тайлан** | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 24,629.70 | - |
| | Мөнгөн хөрөнгө | 24,629.70 | - |
| | Авлага | | - |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **24,629.70** | **-** |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | | |
| | **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **24,629.70** | - |
| **Санхүүгийн үр дүнгийн тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 111,545,290.58 | 159,001,468.02 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 111,545,290.58 | 159,001,468.02 |
| | **Үйл ажиллагааны үр дүн** | | |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | | - |
| | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | | |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - |
| | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - |
| | Тайлант оны үр дүн | - | - |
| | **Эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 111,569,920.35 | 159,001,468.02 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 111,545,290.58 | 159,026,097.79 |
| | **Үйл ажиллагааны ЦМГ** | **24,629.77** | **(24,629.77)** |
| | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **24,629.77** | **(24,629.77)** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 24,629.77 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 24,629.77 | - |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | | |
| | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **209,001,400.00** | **157,897,102.21** |
| | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **209,001,400.00** | **157,897,102.21** |
| | Улсын төсвөөс санхүүжих | 209,001,400.00 | 157,897,102.21 |
| | Хүүгийн орлого | | |
| | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 24,629.77 |
| | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | |

## Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн Халамжийн сангийн хөрөнгийг зарцуулахдаа ХХҮГ нь "*Нийгмийн халамжийн үйлчилгээг хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тулгуурлан хүртээмжтэй хүргэж, хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломж, таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж өрхийн амьжиргааг дээшлүүлж ажиллах*" гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж холбогдох хууль тогтоомжоор заасан нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.

## Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Дөрөв. Аудитын гол асуудал**

Орон нутгийн төсвөөс санхүүжсэн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

**Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

**4.1 Залруулсан алдаа**

Аудитаар залруулах алдаа гараагүй болно.

**4.2 Төлбөрийн акт**

**Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.**

**4.3 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэхээр зөрчил илрээгүй болно

**4.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөхөөр асуудал илрээгүй болно.

**7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

(сая төгрөгөөр)

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | ТШЗ | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | **НИЙТ** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |